



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Музей сургалт судалгааны төв 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2019/132/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь Сайншанд сум 2019 он	Тэргүүлэх аудитор: Ч.Ариунаа Утас: 99092469 Цахим хаяг: Аудитын менежер: Э.Энхцэцэг Утас: 90077079 Цахим хаяг: Аудитор: Г.Энхтөр Утас: 96441690 Цахим хаяг:
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.
Дорноговь аймаг, Төрийн аудитын газар, Сайншанд сум, Орон нутгийн өмчийн 3-р байр

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал	9
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	9
2.11	Шилэн дансны мэдээлэл	10
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга	10
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	10
3	Менежментийн захидал	11
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	12

1 Аудитын гэрчилгээ


**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТОРИЙН АУДИТЫН ГАЗАР**
44103 Дорноговь аймags, Сэйшивад сум,
3 дугаар баг, Орон нутагтай замын III бүлэг,
Утас: (703) 2-27-34

2019. 02. 26 № 1-6/210
Төвийн _____ -ны № _____ -т

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН
МУЗЕЙ, СУРГАЛТ, СУДАЛГААНЫ
ТӨВИЙН ДАРГА
Л.ЭРДЭНЭБАТ ТАНАА**

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Музей, сургалт, судалгааны төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорноговь аймгийн Музей, сургалт, судалгааны төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Музей, сургалт, судалгааны төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Дорноговь аймгийн Музей , сургалт , судалгааны төв нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

 Ч.АРИУНАА

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Музей сургалт судалгааны төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Төвийн захирал Л.Эрдэнэбатад танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Музей сургалт судалгааны төвийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Музей сургалт судалгааны төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.02.18-наас 2019.02.19-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.19-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газар хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Музей сургалт судалгааны төв 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь төрийн аудитын газарт 2019.02.18-ны өдөр байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Дорноговь аймгийн Музей сургалт судалгааны төвийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Дорноговь аймгийн Музей сургалт судалгааны төв нь Түүх соёлын өв , дурсгалт зүйлийг эзэмших , ашиглах , хадгалж хамгаалах , судлах, түгээн дэлгэрүүлэх гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Дорноговь аймгийн Музей сургалт судалгааны төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Түүх соёлын өв , дурсгалт зүйлийг эзэмших , ашиглах , хадгалж хамгаалах , судлах, түгээн дэлгэрүүлэх

Дорноговь аймгийн Музей сургалт судалгааны төвийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Дорноговь аймгийн Музей сургалт судалгааны төвийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Дорноговь аймгийн Музей сургалт судалгааны төвийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн Acolous ” програм хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Музей сургалт судалгааны төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Дорноговь аймгийн Музей сургалт судалгааны төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 1 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлын 0.2 хувиар сонгов.

Нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь батлагдсан төсвийн дагуу зардлыг улсын төсвөөс санхүүжүүлж байгаатай холбоотой юм.

Дорноговь аймгийн Музей сургалт судалгааны төвийн 2018 оны нийт зардал 229,075.00 мянган төгрөг бөгөөд түүний 0.2 хувь болох 458.15 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 1 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 6 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	1	26,870.20	
2	Төлбөрийн акт тогтоосон	0	0.00	
3	Албан шаардлага өгсөн	0	0.00	
4	Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн	0	0.00	
5	Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн	0	0.00	
	Дүн	1	26,870.20	

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудал байхгүй байна.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

- Байхгүй

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Дорноговь аймгийн Музей сургалт судалгааны төвийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой арга хэмжээнд зориулан 2018 онд 191,163.7 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 190,594.14 мянган төгрөг буюу 99,7 хувьтай байгаа нь Үндсэн үйл ажиллагааны орлого төлөвлөгөөнөөс давж биелэснээс шалтгаалжээ.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Музей сургалт судалгааны төвийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Музей сургалт судалгааны төвийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Дорноговь аймгийн Музей сургалт судалгааны төвийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Дорноговь аймгийн Музей сургалт судалгааны төвийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Няравын бараа материалын тайланг нэр төрлөөр гаргаагүй

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2019 оны 6 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

3.1 Балансын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Няравын бараа материалын тайланг нэр төрлөөр гаргаагүй

Энэ нь санхүүгийн тайлан үнэн зөв байх, бодитой оршин байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүйгээс гадна Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар баталсан заавар , Боловсрол соёл , шинжлэх ухаан , спортын сайдын 2017 оны 2-р сарын 7-ны өдрийн А/40 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг тус тус зөрчсөн байна.

3.1.2 Эрсдэл:

Бараа материалын тайланг нэр төрлөөр гаргадаггүй, хөрөнгө шамшигдах

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар баталсан заавар , Боловсрол соёл , шинжлэх ухаан , спортын сайдын 2017 оны 2-р сарын 7-ны өдрийн А/40 тоот тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан бараа материалд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:

Санал байхгүй

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Төгрөгөөр

	Үзүүлэлт	ҮЛДЭГДЭЛ	ГҮЙЦЭГНЭЛ
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	19,988,865.44	26,870,190.44
27	АВЛАГА	450,000.00	-
28	Ажиллагсдтай холбогдсон авлага	450,000.00	-
60	БАРАА МАТЕРИАЛ	19,538,865.44	26,870,190.44
66	Хангамжийн материал	19,538,865.44	26,870,190.44
67	Бичиг хэргийн материал	3,394,180.00	5,011,770.00
68	Аж ахуйн материал	523,750.00	1,238,750.00
69	Салбар хэргээл	1,090,000.00	1,336,000.00
70	Түлш шатах тослох материал	689,920.00	466,245.00
71	Барилгын шаардлын материал	3,136,700.00	9,378,900.00
73	Бусад хангамжийн материал	10,704,315.44	9,438,525.44
86	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	852,148,765.12	897,496,743.41
106	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	852,148,765.12	897,496,743.41
108	Билет хөрөнгө	852,148,765.12	886,904,743.41
109	Барилга, байгууламж	342,980,258.00	196,400,280.00
110	Хуримтлагдсан зээгдэл	(208,826,360.77)	0.00
111	Авто тээврийн хэрэгсэл	49,020,000.00	49,020,000.00
112	Хуримтлагдсан зээгдэл	138,516,666.46	(48,564,999.96)
113	Машина, тоног төхөөрөмж	84,564,097.90	84,564,097.90
114	Хуримтлагдсан зээгдэл	(67,323,348.68)	(82,387,816.16)
115	Танхимга, аж ахуйн эд хогшил	52,461,015.00	52,461,015.00
116	Хуримтлагдсан зээгдэл	(28,746,958.54)	(71,124,562.04)
121	Түүх соёлын дурсгалт зүйлс	664,259,036.00	664,259,036.00
123	Хуримтлагдсан зээгдэл	(93.33)	(93.33)
125	Номын фонд	2,277,786.00	2,277,786.00
126	Билет бус хөрөнгө	-	10,592,000.00
127	Програм хангамж	-	1,424,500.00
128	Хасагдуулга	-	(1,424,500.00)
129	Бусад билет бус хөрөнгө	1,424,500.00	10,592,000.00
130	Хасагдуулга	(1,424,500.00)	-
137	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	872,137,630.56	924,366,933.85
138	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	945,000.00	-
139	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	945,000.00	-
164	Өглөг	945,000.00	-
165	Ажиллагсдтай холбогдсон өглөг	945,000.00	-
214	ЦЭВЭР ХӨРӨНГ ӨӨМЧИЙН ДҮН	871,192,630.56	924,366,933.85
215	Засгийн газрын хувь оролцоо	871,192,630.56	924,366,933.85
216	Засгийн газрын оруулсан капитал /ЗГ Сан/ орон нутгийн сан	385,749,581.05	396,341,581.05
217	Өмгөс: -Төрийн өмгөс	385,749,581.05	396,341,581.05
223	Хуримтлагдсан үр дүн	(157,915,126.75)	(115,956,608.25)
224	Өмлох үеийн үр дүн	(157,915,126.75)	(157,915,126.75)
225	Тайланг үеийн үр дүн	-	41,958,518.50
227	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	643,358,176.26	643,981,961.05
231	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГ ӨӨМЧИЙН ДҮН	872,137,630.56	924,366,933.85

443744312
ESDAR058 5875781

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Төгрөгөөр

	ҮҮҮҮДЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭТГЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СОЛДОРЫН ДҮН (I)	181,484,979.75	271,032,300.00
76	ЛАТВАРЫН БҮС ОРЛОГО	6,219,239.73	83,414,000.00
77	Найрамтгаар ийн орлого	6,219,239.73	83,414,000.00
81	Төсвийн байгууллагын өөрийн орлого	6,219,239.73	83,414,000.00
82	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжилт	6,219,239.73	83,414,000.00
85	Үйлдвэрлэлийн үйлдвэрлэл ашиг орлого	2,829,559.09	3,814,000.00
86	Тусламж, санхүүжилтийн орлого	3,389,689.75	79,600,000.00
111	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,556,040.00	614,000.00
119	Тусгай зориулалтын хөрөнгийн орлогоос санхүүжилт	181,699,700.00	187,008,300.00
122	Төсвийн санхүүжилтийн орлого	1,556,040.00	614,000.00
125	ЭГНХ, бусад эдлэлтэй өмч хөрөнгө түүхийн ашигтай өмчлөлтэй үйлдвэр хөрөнгөөс	1,556,040.00	-
126	Дотоод орлого төсвийн зөвхөнхчлэл төсвийн сурталчилсан төсвийн доош ашигтай төсвийн тусгай тус	-	834,000.00
147	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	183,318,823.51	216,864,693.51
148	УРСГАЙ ЗАРДАЛ	183,318,823.51	216,864,693.51
149	ВАРГА, АЖИЛ УЯАЛЫН ГЭРЭЭНИЙ ЗАРДАЛ	183,318,823.51	216,026,837.51
150	Цалин, хөлс бусад халамжийн зардал	94,635,815.03	113,698,099.00
151	Цалин	94,635,815.03	113,698,099.00
157	Ажил эрхлэгчид өгөх өөрийн хөрөнгө түүхийн ашигтай өмчлөлтэй үйлдвэр хөрөнгөөс	10,524,791.00	13,708,636.00
158	Тусгай зориулалтын зардал	6,693,513.00	9,172,550.00
159	Тусгай зориулалтын зардал	774,808.00	1,140,835.00
160	ҮНДЭН өмчийн ашигтай өмчлөлт	916,643.00	818,853.00
161	Ажил гүйцэтгэлийн ашигтай өмчлөлт	211,377.00	221,200.00
162	Эрүүл мэндийн ашигтай өмчлөлт	1,067,947.00	2,251,988.00
164	Бусад ашигтай өмчлөлт	39,829,970.00	40,792,154.00
165	Тэрлэлт зардал	3,118,398.00	3,634,604.00
166	Тусгай зориулалтын зардал	33,346,330.00	41,184,000.00
167	Цэцэр, бусад зардал	1,365,736.00	1,373,404.00
170	Хөдөлгөөн, барилд мөргөлийн зардал	1,653,955.00	3,606,645.00
171	Өмчийн хөрөнгө түүхийн зардал	251,230.00	1,211,110.00
172	Төсвийн зардал	329,930.00	1,265,725.00
173	Шуудан хөрөнгө түүхийн зардал	972,688.00	1,052,110.00
181	Нэрлэгчийн зардал	403,210.00	373,990.00
184	Нэрлэгчийн зардал, зөвхөн зардал	403,210.00	373,990.00
189	Эвчлэл, үрэгтэй зардал	853,400.00	1,299,400.00
189	Урьдчилсан зардал	853,400.00	1,299,400.00
190	Төсвийн зардал	400,500.00	324,600.00
192	Дотоод төсвийн зардал	400,500.00	324,600.00
194	Бусад үйлдвэрлэлийн зардал, тусгай зориулалтын зардал	2,827,020.00	3,365,820.00
197	Бусад үйлдвэрлэлийн зардал өөрийн өмчлөлтэй үйлдвэр хөрөнгөөс	3,291,890.00	2,663,660.00
199	Аудит, бичиг баримт зориулалтын зардал	-	120,000.00
197	Дотоод зардал	79,500.00	-
198	Төсвийн зардал	47,510.00	33,500.00
199	Төсвийн зардал	10,000.00	10,000.00
201	Салбар зардал	7,090.00	7,090.00
207	Банк санхүүгийн байгууллагын үйлдвэрлэлийн зардал	391,430.00	329,270.00
209	Бусад үйлдвэрлэлийн зардал	31,100,630.51	33,258,718.51
212	Үндсэн хөрөнгийн зардал, өөрчлөлт	31,100,630.51	33,258,718.51
224	УРСГАЙ ШИШЭВЭР	-	838,150.00
227	Ужирч төсвийн өргөсөн санхүүжилт, санхүүжилт	-	838,150.00
240	Төсвийн зардал	-	838,150.00
268	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III-IV)	8,136,150.24	94,157,000.00
276	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	12,209,087.99
277	Үндсэн хөрөнгө худалдлын үр	-	12,209,087.99
283	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮС ҮР ДҮН (VI-VI.V)	-	12,209,087.99
288	НИЙТ ҮР ДҮН (VII-VI-VI)	8,136,150.24	41,578,518.30



АУДИТ ХИЙГДСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Төгрөгөөр

	ҮЗҮҮГЭЛТ	ГҮЙЦЭТГЭЛ	ГҮЙЦЭГТЭЛ
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	104,764,390.00	191,432,300.00
27	ТАТВАРЫН БҮС ОРЛОГО	1,630,850.00	3,814,000.00
78	Нийтэлт татварын бүс орлого	1,630,850.00	3,814,000.00
82	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,630,850.00	3,814,000.00
83	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,630,850.00	3,814,000.00
110	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	103,133,540.00	187,618,300.00
118	Тусгай зориулалтын шинжүүлтгээс санхүүжих	101,597,500.00	187,004,300.00
121	Нөөцт санхүүжилтийн орлого	1,536,040.00	614,000.00
124	ЭНХ, ЗДНХоронго түүнтэй адилтгах хөрөнгийн төсвийн хөрөнгөөс	1,536,040.00	-
125	Дээд шатны төсвийн хоорондох төсөвт тусгагдсан төсвөөс доо шатны төсвийн шан	-	614,000.00
147	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЭЗЭЛНИЙ ДҮН (II)	89,927,045.00	191,432,300.00
148	УРСГАЛ ЗАРДАГ	89,927,045.00	191,432,300.00
149	БАРАА АЖИЛ ГҮЙЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	89,927,045.00	190,594,144.00
150	Цанх, мөсө бөхөн нэмэгдэх урамшиг	52,837,983.00	113,699,000.00
151	Үндсэн шилэн	5,867,533.00	11,203,624.00
157	Ажил өгчөөс шийтгэл авалтад төвөг шийтгэл	4,189,604.00	11,047,905.00
158	Түгээрлийн давтгалын шийтгэл	335,587.00	801,530.00
159	Тэтгэмжийн давтгалын шийтгэл	419,481.00	627,783.00
160	ҮОМШ өгчийн давтгалын шийтгэл	83,896.00	156,947.00
161	Ажилгүйдлийн давтгалын шийтгэл	838,965.00	1,569,459.00
162	Эрүүд мэсдийн давтгалын хуралж	26,162,351.00	46,528,356.00
164	Байр ашиглалтын хөрөнгийн төгтмэл зардал	1,871,679.00	3,634,604.00
165	Гэрээ шилжүүлэх зардал	23,581,460.00	41,184,066.00
166	Түрэл, халгалтын зардал	709,412.00	1,709,664.00
170	Хөтөлж, бараа материалын зардал	1,158,346.00	2,224,660.00
171	Бичиг зардал	288,210.00	666,500.00
172	Төсөөр, шатахуун	295,520.00	466,050.00
173	Шуудан, холбоо, интернетын талбар	374,616.00	1,092,110.00
181	Норматив зардал	320,000.00	692,000.00
184	Нормын хүчинс, зөвлөх зэдэл	320,000.00	692,000.00
185	Эд хөдөөл, урсгал төсвийн зардал	455,700.00	7,562,600.00
187	Танцлага	-	2,888,750.00
189	Урсгал засвар	455,700.00	4,673,850.00
190	Төмнөлт, хэвч зардал	117,000.00	324,600.00
192	Дотоод нөхөн төлбөрт	117,000.00	324,600.00
194	Бусдаар гүйцэтгүүлсэн давж, үйлчилгээний талбар, зураамж	2,987,932.00	5,359,326.00
195	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний талбар, хуралж	2,626,496.00	4,659,360.00
196	Аудит, баталгаажуулалт, зөвлөх зэдэл төгтөөс	-	120,000.00
198	Төсвийн хэрэгсэлийн зардал	47,510.00	33,500.00
199	Төсвийн хэрэгсэлийн өмчлөлтөө	-	10,000.00
201	Газрын талбар	7,096.00	7,096.00
202	Банк санхүүгийн байгууллагын үйлчилгээний зураамж	306,830.00	529,370.00
221	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	838,156.00
234	Урсгал төсвөөс өгчөөс санхүүжилт, шинжүүлтг	-	838,156.00
237	Төвлөрүүлэх шинжүүлтг	-	838,156.00
250	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)-(I)-(II)	14,837,345.00	-
251	ХОРОНГО ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
279	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
303	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	14,837,345.00	-
304	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн төсвийн үндсэд	-	-
305	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн төсвийн үндсэд	14,837,345.00	-



АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Төгрөгөөр

	ҮЗҮҮ ТЭЛТ	ТӨЛӨВ, ЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хуви
1	Монго, түүнтэй адилтгах хөрөнгийн эзний үлдэгдэл	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЭЗЭДЛИЙН ДҮН	190,549,700.00	189,980,144.00	569,556.00	99.70
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	190,549,700.00	189,980,144.00	569,556.00	99.70
4	Бараа, үйлчилгээний зардал	190,549,700.00	189,980,144.00	569,556.00	99.70
5	Цалин хөлс болон ажлагдах урамшил	113,699,000.00	113,699,000.00	-	100.00
6	Унагын шатин	113,699,000.00	113,699,000.00	-	100.00
11	Ажлын өртөөсөө шийтгэлийн даатгалд төлөх шалтгаан	14,423,900.00	14,203,624.00	220,276.00	98.47
12	Тэтгэлийн даатгал	9,835,940.00	11,017,905.00	(1,211,965.00)	112.32
13	Тэтгэмжийн даатгал	946,990.00	801,530.00	145,460.00	84.64
14	ҮСМЦНЭ НИЙ ДААТГАЛ	1,117,592.00	677,783.00	489,809.00	56.17
15	Акцидүндэний даатгал	229,398.00	156,947.00	72,451.00	68.42
16	Зрүүд мөндрийн даатгал	2,293,980.00	1,569,459.00	724,521.00	68.42
17	Байр ашигласантай холбоотой тогтмол зардал	46,654,900.00	46,528,334.00	126,566.00	99.73
18	Гэрээ сахиулагд	2,919,300.00	3,634,604.00	(715,304.00)	124.50
19	Туша, халагт	82,284,100.00	41,184,066.00	41,100,034.00	97.40
20	Цэвэр, бохир ус	1,451,500.00	1,709,664.00	(258,164.00)	117.79
22	Хангамж, бараа материалын зардал	2,225,300.00	2,224,660.00	640.00	99.97
23	Бичиг хэрэг	630,600.00	666,500.00	(35,900.00)	105.69
24	Төхөөр (патакхуу)	551,800.00	466,020.00	85,780.00	84.46
25	Шүүдэн холбоо, интернетын тоолбор	1,012,900.00	1,092,110.00	(49,210.00)	104.72
30	Нормалог зардал	692,000.00	692,000.00	-	100.00
33	Нармын хувцас зонхон эхлэл	692,000.00	692,000.00	-	100.00
34	Эд хөрөнгийн худалдан авал	7,562,600.00	7,562,600.00	-	100.00
36	Ташага	6,000,000.00	2,888,750.00	3,111,250.00	48.15
38	Урсгал мөхөөр	1,562,600.00	4,673,830.00	(3,111,230.00)	299.11
39	Төмнөлт, зочин зардал	324,600.00	324,600.00	-	100.00
41	Дотоод албан төмнөлт	324,600.00	324,600.00	-	100.00
43	Бусадар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний тоолбор	4,967,400.00	4,745,326.00	222,074.00	95.53
44	Бусадар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний тоолбор, хураамж	4,045,400.00	4,045,360.00	40.00	100.00
45	Аудит, бичигт хураамж, гэрээтэй тогтоох зардал	142,500.00	120,000.00	22,500.00	84.21
47	Тээврийн хэрэгслийн татвар	95,000.00	33,500.00	61,500.00	35.26
48	Тээврийн хэрэгслийн оноонлого	19,000.00	10,000.00	9,000.00	52.63
50	Газрын тоолбор	12,500.00	7,096.00	5,404.00	56.77
51	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	653,000.00	529,370.00	123,630.00	81.07
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛГЭХ ЭХ ҮҮСВЭР	190,549,700.00	190,818,300.00	(268,600.00)	100.14
98	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	187,004,300.00	187,004,300.00	-	100.00
101	Тусгай зориулалтын санхүүжүүлэх санхүүжих	187,004,300.00	187,004,300.00	-	100.00
110	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛАГААНААС	3,545,400.00	3,814,000.00	(268,600.00)	107.38
111	Учлал үйл ажиллагааны өртөөсөө санхүүжих	3,545,400.00	3,814,000.00	(268,600.00)	107.38
127	Монго, түүнтэй адилтгах хөрөнгийн эзний үлдэгдэл	-	-	-	-
128	Монго, түүнтэй адилтгах хөрөнгийн эзний үлдэгдэл	-	-	-	-
129	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
130	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	15	-	-	-
134	Удирдах ажилтан	1	-	-	-
135	Гувицгал ажилтан	8	-	-	-
136	Унагчид ажилтан	6	-	-	-
138	СУРАЛЦАГЧДЫН ТОО /ажлын худалбар/	-	-	-	-
148	ЭМЧЛҮҮЛЭССЭДИЙН ТОО	-	-	-	-



АУДИТ ХИЙГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Төгрөгөөр

	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хуви
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦӨЖЭР ЗЭЭЛИЙН ДҮН	614,000.00	614,000.00	-	100.00
3	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	614,000.00	614,000.00	-	100.00
4	Барил, үйлчилгээний зардал	614,000.00	614,000.00	-	100.00
43	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	614,000.00	614,000.00	-	100.00
44	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, зураамж	614,000.00	614,000.00	-	100.00
97	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	614,000.00	614,000.00	-	100.00
120	Нэгжээт санхүүжилтийн орлого	614,000.00	614,000.00	-	100.00
124	Дээд нэгжээт төсвийн захирагчтай төсөвт тусгалдан төсвөөс дээд шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	614,000.00	614,000.00	-	100.00
127	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
128	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
129	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
130	БАЙГ УУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
133	АЖИЛЛАГСДЫН ТОО	15	-	-	-
134	Улирдаг ажилтан	1	-	-	-
135	Гүйцэтгэх ажилтан	8	-	-	-
136	Үйлдэх ажилтан	6	-	-	-
138	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дундаар/	-	-	-	-
148	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	-	-	-	-

4417/4420
E0A0055 82120